



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/39

Пионер толгой

Гурванбулаг сумын 2023 оны нэгдүгээр
ээлжийн цэргийн жинхэнэ албаны цэрэг татлагын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, Засгийн газрын 2022 оны мн/209 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын Нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын "Цэргийн жинхэнэ албаны халалт, татлагын ажлыг зохион байгуулах тухай" 2023 оны н/60 дугаар тушаал, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд цэргийн жинхэнэ албанд иргэдийг татах ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж явуулсугай.

2.Цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	Р.Гантулга	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Г.Сүхбаатар	Эрүүл мэндийн төвийн дарга
	Д.Буянаа	Насан туршийн боловсролын нэгжийн менежер
	Х.Мядагбадам	Нийгмийн даатгалын байцаагч
	Б.Лувсаншийрэв	Цэнгэл 1 дүгээр багийн Засаг дарга
	Д.Мөнхчулуун	Давааны ам 2 дугаар багийн Засаг дарга
	Д.Болд-Аюуш	Буга 3 дугаар багийн Засаг дарга

642201261

2023/Засаг дарга/Захирамж2023

Б.Баттулга

Хөвийн ам 4 дүгээр багийн

Засаг дарга

Ч.Батцэцэг

Пионер толгой 5 дугаар багийн

Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхдалай

Нийгмийн бодлогын

мэргэжилтэн

3.Цэрэг татлагын ажилд шаардагдах 400,000 (Дөрвөн зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга, Цэрэг татлагын товчооны дарга (Р.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНТУЛГА